

**2019 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛААР
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2019.06.04

№16

Дархан

№	Өгсөн үүрэг даалгавар	Хэрэгжилт	Хариуцах хэлтэс, агентлаг
1.	<p>2019 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд Дархан-Уул аймагт ажиллах гэж буйтай холбогдуулан ерөнхий төлөвлөгөө гарсан. Уг төлөвлөгөөний дагуу тус өдөр 16:00 цагаас 18:00 цагийн хооронд аймгийн боловсрол, соёл, урлагийн салбарын ажилтнуудтай уулзалт хийнэ. Иймд орон нутгийн холбогдох удирдах албан тушаалтнууд хуваарийн дагуу оролцоно. Мөн өдрийн 18:00 цагаас 19:00 цагийн хооронд боловсролын чиглэлээр Дархан-Уул аймагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлын явцтай танилцана. Иймд холбогдох удирдлагууд Спорт цогцолборын барилгын ажлын одоогийн нөхцөл байдал болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай танилцуулж мэдээлэл өгөх хэрэгтэй байна.</p>	<p>Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын яам, Боловсролын хүрээлэнгээс хамтран зохион байгуулсан “Сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан үр дүнгийн бүсийн хэлэлцүүлэг”-т Булган, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгийн нийт 56 багш нарын төлөөллийг оролцуулж зохион байгууллаа. Хэлэлцүүлгийг нээж БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг, Сургалтын цөм хөтөлбөрийн сайжруулсан явцын талаар БСШУСЯ-ны Ерөнхий Боловсролын Бодлогын Газрын дарга Т.Ням-Очир нар танилцуулга хийсэн. 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдөр БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг боловсрол, соёл, урлаг, шинжлэх ухаан, спортын салбарын нийт 600 гаруй ажилтнуудтай уулзалт хийсэн. Уулзалтад аймгийн удирдлагууд болон ЕБС-ийн захирал, СӨББ-ын эрхлэгч, соёлын байгууллагын дарга, захирал, зарим ТББ-ын төлөөллүүд оролцсон. Уулзалтад оролцсон ажилтнуудаас 15 санал, бичгээр 33 санал, асуулт ирснийг аймгийн Засаг дарга болон</p>	<p align="center">Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёл урлагийн газар</p>

		<p>БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг, УИХ-ын гишүүн Б.Жавхлан нар газар дээр нь тодорхой хариултыг өгч, зарим асуудлыг шийдвэрлэсэн.</p> <p>Уулзалтын дараа БСШУС-ын сайд ЕБС, СӨББ-ын болон “Спорт цогцолбор”-ын барилгын ажлын явцтай танилцан төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтанд оруулахад дэмжих, Дархан сумын 4-р сургуулийн барилгын санхүүжилтийг 2020 оны улсын төсөвт багтаан суулгахаар шийдвэрлэсэн.</p>	
2.	<p>Сумдууд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн зарлалыг сайн түгээх хэрэгтэй байна. Түүнчлэн энэ 7 хоногт хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуй, зам тээвэр, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл болон өвөлжилтийг хэрхэн давсан тухай асуудлаар хэвлэлийн бага хурал хийх төлөвлөгөөтэй байна. Иймд холбогдох хэлтэс, агентлагийн дарга нар хэвлэлийн бага хуралд оролцож иргэд олон нийтэд мэдээлэл өгөх хэрэгтэй.</p>	<p>Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулан олгох хөнгөлөлттэй зээлд хамрагдах иргэн, аж ахуй нэгжүүдийн сонгон шалгаруулалтын зар мэдээг www.darkhan.gov.mn, Дархан-Уул аймаг фейсбүүк хуудас, ЖДҮ Дархан фейсбүүк хуудас, Хүнс, хөдөө аж ахуйн газрын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэсэн. Мөн иргэдэд утсаар тогтмол мэдээллүүдийг хүргэж байна. Төслийн материалыг 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хүлээн авна. “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн талаар Стандарт хэмжилзүйн хэлтсийн дарга И.Алтанцэцэг, Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны дарга Б.Оюунтөгс хөдөө аж ахуйн цаг үеийн ажлын талаар 2019 оны 06 сарын 05-ны өдөр тодруулга ярилцлага нэвтрүүлэгт оролцож, иргэд олон нийтэд мэдээлэл өгсөн.</p>	<p>Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс,</p>

		<p>“Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын болон зам ашигласны төлбөр хураамж”-ийн талаар 2019 оны 05 дугаар сарын 29-ны өдөр Автотээврийн төв, Цагдаагийн газар, Дархан Орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ, Татварын хэлтсээс хэвлэлийн бага хурал хийж иргэд, олон нийтэд мэдээлэл өгсөн.</p>	
3.	<p>Сүүлийн үед тендерийн материалын бүрдүүлэлтэд алдаа дутагдал гардаг болсон. Иймд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ болон Орон нутгийн өмчийн газар ажлын уялдаа холбоогоо хангаж ажиллах хэрэгтэй байна. Мөн өнөөдрийн шуурхай хуралд аймгийн ерөнхий архитектор Д.Элдэвсайхан ирээгүй байна. Баярсайхан дарга Элдэвсайханд хариуцлага тооцох шаардлагатай байна. Элдэвсайхан удаа дараа ажлын хариуцлага алдаж алдаа дутагдал гаргаж байна. Мөн Мягмар гараг бүрийн өглөө хуралддаг хөрөнгө оруулалтын ажлын хуралд суух ёстой боловч суухгүй байна. Аймгийн ерөнхий архитектор тун хариуцлагагүй ажиллаж байна. Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.</p>	<p>Тендерийн материалын бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтад аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, Орон нутгийн өмчийн газар тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ хяналт тавьж ажиллаж байгаа. 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн өглөөний Шуурхай хуралд аймгийн Засаг даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу аймгийн Ерөнхий архитектор Д.Элдэвсайханд сануулах арга хэмжээ авах тухай өөрт нь урьдчилан мэдэгдэж, аймгийн Засаг даргын Шуурхай хурлын тэмдэглэлийг ТЗУХ-ийн дарга П.Баярсайхан танилцуулж, сонсох ажиллагаа хийсэн. Захирамжийн төслийг танилцуулахад бэлэн болсон.</p>	<p>Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар</p>

4.	Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ болон ХОХБТХ аймгийн ИТХ-ын холбогдох хороотой хамтран Барилга Захиалагчийн албаны хийж хэрэгжүүлж буй ажилд хяналт шалгалт хийх хэрэгтэй байна. Мөн аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, багуудын дарга нартай хамтран хяналтын камерын ашиглалтад хяналт тавих хэрэгтэй байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хөндлөнгийн аудитын ажлын хэсэг “Дархан Ус суваг” ХК-д ажиллаж байна.	Хяналт шалгалт хийх ажлын удирдамжийг 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдөр аймгийн Засаг даргаар батлуулан, 2019 оны 06 дугаар сарын 04-ны өдөр нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ, “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-уудад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, Цагдаагийн газартай хамтран Дархан сумын багуудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор суурилуулагдсан хяналтын камерын ашиглалтад хяналт шалгалт хийж байна.	Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэс
5.	10 жилээс дээш хугацаагаар төрийн алба хааж байгаа албан хаагчдыг гадаад дотоод сургалтанд хамруулж байх асуудлыг байгууллагын дотоод журамд оруулж байх шаардлагатай.	Энэ асуудлаар агентлагуудад чиглэл өгүүлэхээр Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл аймгийн ЗДТГ-ын даргад танилцуулахаар бэлтгэлээ.	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

ХЭРЭГЖИЛТТЭЙ ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

С.НАСАНБАТ

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

П.БАЯРСАЙХАН

ХЭРЭГЖИЛТИЙГ НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Х.ЗОЛЖАРГАЛ